САР ТУТМЫН МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН ТОЙМ

ЗУРГААДУГААР САР 2018

ИНФОГРАФИК: ГОЛЛОХ ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Өмнөх сартай харьцуулсан үзүүлэлт

ДНБ
6.1%
2018 оны I-р улирлын байдлаар

ИНФЛЯЦИ
7.2%

ТӨГРӨГИЙН АМ.ДОЛЛАРТАЙ ХАРЬЦАХ ХАНШ
2432.30төг

ТӨСВИЙН АЛДАГДАЛ
12.9 тэрбум төг

ГАДААД ХУДАЛДАА
822.2 сая АМ.ДОЛЛАР

ЭКСПОРТЫН ГОЛ БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ХЭМЖЭЭ БОЛОН ДУНДАЖ ҮНЭ

Экспортын гол бүтээгдэхүүний хэмжээ болон дундаж үнийг графикаар оны эцсийн байдлаар харуулав.



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

ИНФОГРАФИК- САР ТУТМЫН БУСАД ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Өмнөх сартай харьцуулсан үзүүлэлт

ГАДААД ВАЛЮТЫН НӨӨЦ
3.2 ТЭРБУМ ДОЛЛАР

ЧАНАРГҮЙ ЗЭЭЛИЙН ХУВЬ
8.5%

НИЙТ ХАДГАЛАМЖ
11.7 ИХ НАЯД ТӨГ

ОРОН СУУЦНЫ ҮНИЙН ИНДЕКС
1.027 НЭГЖ

ГҮЙЛГЭЭНД БАЙГАА БЭЛЭН МӨНГӨ
931 ТЭРБУМ ТӨГ

МОНГОЛБАНКНЫ БОДЛОГЫН ХҮҮ
10%

ЭДИЙН ЗАСАГ ЯМАР БАЙХ ВЭ?- ТААМАГ (ОУЭЗБ)

ДНБ-ий өсөлт: 2018 онд: +3.8%, 2019 онд: +4.3%
Инфляци: 2018 онд:+8%, 2019 онд +7%
Урсгал тэнцэл: 2018 онд ДНБ-ий -6.3%, 2019 онд: -7%-тай байхыг Азийн хөгжлийн банк (АЗХБ) 2018 он 4-р сарын тайландаа тоймлосон байна.

Эх сурвалж: https://bit.ly/2HJFlip

ДНБ-ий өсөлт: 2018 онд: +5%, 2019 онд: +6.3%
Инфляци: 2018 онд: +6.4%, 2019 онд: +6.8%,
ДНБ-д эзлэх урсгал тэнцэл: 2018 онд: -6.4%, 2019 онд: -8.3%- Олон улсын валютын сан (ОУВС)-аас гаргадаг (Дэлхийн эдийн засгийн төлөв байдлын судалгаа, 2018 он 4-р сар) тайланд дурдсан байна.

Эх сурвалж: http://bit.ly/2zsmvYo

САР ТУТМЫН МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН ТОЙМ

ЗУРГААДУГААР САР 2018

ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТҮҮД:УЛСЫН ТӨСӨВ, ВАЛЮТЫН ХАНШ, ИНФЛЯЦИ, ГАДААД ХУДАЛДАА

Төсвийн тэнцэл 6-р сарын байдлаар 12.9 тэрбумын ашигтай гарав.

Улсын нэгдсэн төсвийн орлого өнгөрсөн жилийн мөн үеэс 26.3 хувиар өсч, зарлага 2.7 хувиар өссөн бол төсвийн тэнцвэржүүлсэн нийт тэнцэл 12.9 тэрбум төгрөгийн ашигтай гарав. Төсвийн алдагдал өнгөрсөн оны мөн үед 740 тэрбум төгрөгийн алдагдалтай байсан бол энэ сард 12.9 тэрбум төгрөгийн ашигтай гарав.



Ам.долларын ханш өмнөх сараас 27 төгрөгөөр нэмэгдэв.

Зургаадугаар сард Монголбанкны төгрөгийн ам.доллартай харьцах нэрлэсэн дундаж ханш өнгөрсөн оны мөн үеэс 64 төгрөг буюу 2.7 хувиар нэмэгдэж, өмнөх сартай харьцуулахад 27 төгрөг буюу 1.1 хувиар нэмэгдэж 2432.30 төгрөг болов. 5-р сард гадаад валютын нөөц 3.2 тэрбум төгрөг болж өнгөрсөн оны мөн үеэс 3 дахин нэмэгдсэн байна.



Инфляцийн түвшин 7.2%

Хэрэглээний үнийн индекс улсын хэмжээнд 2018 оны 6-р сарын байдлаар өмнөх сараас 0.5 хувиар нэмэгдэж, өмнөх оны мөн үеэс 7.2 хувиар, оны эхнээс 5 хувь өсөв. Тус сард ингэж өсөхөд хүнсний бараа, тээврийн хэрэгсэл, түлш, үйлчилгээний үнэ өссөн нь нөлөөлсөн байна.

Гадаад худалдааны тэнцэл 822.2 сая.ам доллар болов.

2018 оны зургаадугаар сарын байдлаар нийт барааны эргэлт 6340 тэрбум төгрөг буюу өмнөх оны мөн үеэс 25.8 хувиар өссөн бол экспорт 15 хувиар нэмэгдэж, импорт өмнөх оны мөн үеэс 42 хувиар өсч гадаад худалдааны тэнцэл 822.2 сая ам.долларын ашигтай гарлаа.



ХУУДАС 2

6-Р САРЫН ОНЦЛОХ: ЗЭЭЛ



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

ААН, байгууллага, иргэдэд олгосон нийт зээлийн өрийн үлдэгдэл 2018 оны 6-р сард өмнөх сараас 2.9 хувиар нэмэгдэж, өнгөрсөн оны мөн үеэс 19.4 хувиар нэмэгдэж 15.4 их наяд төгрөг болов. Чанаргүй зээлийн хэмжээ 1317 тэрбум төгрөг болж, өмнөх сараас 7.9 хувиар нэмэгдэж, өнгөрсөн оны мөн үеэс 16.3 хувиар нэмэгдэв. Нийт зээлд эзлэх чанаргүй зээлийн өрийн үлдэгдэл 8.5% байна

Хугацаа хэтэрсэн зээлийн өрийн үлдэгдэл 2018 оны 6 дугаар сарын эцэст 829.5 тэрбум төгрөг болж, өмнөх сараас 111.2 (11.8%) тэрбум төгрөгөөр буурч, өмнөх оны мөн үеэс 32.5 (4.1%) тэрбум төгрөгөөр өсжээ. Хугацаа хэтэрсэн зээлийн өрийн үлдэгдэл нийт зээлийн өрийн үлдэгдлийн 5.4 хувийг эзэлж байна.

Банкны системийн хэмжээгээр чанаргүй зээл 2018 оны 6 дугаар сарын эцэст 1.3 их наяд төгрөг болж, өмнөх сараас 96.9 тэрбум төгрөг (7.9%), өмнөх оны мөн үеэс 184.7 (16.3%) тэрбум төгрөгөөр өсжээ.

Үнэт цаасны арилжаагаар 2018 онд эхний хагас жилд 290.7 тэрбум төгрөгийн гүйлгээ хийж, 384.9 сая ширхэг үнэт цаас арилжсан нь өмнөх оны мөн үеэс гүйлгээ 501.8 (63.3%) тэрбум төгрөгөөр буурчээ.

САРЫН ОНЦЛОХ:INVEST MONGOLIA ХУРАЛ БОЛОВ, ВАЛЮТЫН ЗОХИЦУУЛАЛТЫН ХУУЛЬ ШИНЭЧЛЭГДЭНЭ.

- Засгийн газраас хэрэгжүүлж буй "Гурван тулгуурт хөгжлийн бодлого"-ын хүрээнд ирэх гурван жилд хэрэгжих 115 төсөлд нэг тэрбум гаруй ам.долларын хөрөнгө оруулалт шаардлагатай гэвч Монгол Улсад хөрөнгө оруулалт татарсан. Тухайлбал уул уурхайн салбарт 9 төсөлд 3.5 тэрбум ам.доллар, эрчим хүчний салбарын 15 төсөлд 3.2 тэрбум ам.доллар, хүнс, хөдөө аж ахуйн салбарын 6 төсөлд 432 сая ам.доллар шаардлагатай байгааг Үндэсний хөгжлийн газраас мэдэгдсэн. Энэ хүрээнд Үндэсний хөгжлийн газраас хөрөнгө оруулалт татах зорилгоор Invest Mongolia хөрөнгө оруулалтын хурлуудыг гадны улсад зохион байгуулав. 2018 оны 6-р сард Лондон хотод мөн Германы санхүүгийн төв Франкфурт хотод болов.

- 1994 онд батлагдан гарч өнгөрсөн хугацаанд 19 удаа нэмэлт өөрчлөлт орсон "Валютын зохицуулалтын тухай хууль"-ийг ил тод, нээлттэй, олон улсын стандартад нийцүүлэн хөгжүүлэх зорилгоор өөрчлөн шинэчлэх ажлын хэсэг гарав. Тус хуульд валютын орох, гарах урсгалыг зохицуулах, валютын захын зохицуулалтыг тодорхой болгож оролцогчийн ханшийн эрсдлийг бууруулах, санхүүгийн үүсмэл хэрэгслийн хэрэглээг нэмэгдүүлэх, валютын бирж байгуулах, валютын зохицуулалтын талаарх төрийн байгууллагын уялдааг сайжруулж хяналтыг тодорхой болгох, валютын албан ханшийг зарласан ханш гэж нэрлэх зэргээр хуулийн нийт заалтын 50-иас дээш хувийг шинэчлэх талаар мэдэгдэв.

Эх сурвалж:

1. *Статистикийн бюллетень, 6-р сар 2018 он, Үндэсний статистикийн хороо*
2. *Статистикийн бюллетень, 6-р сар 2018 он, Монголбанк*
3. *www.1212.mn, www.mongolbank.mn, www.montsame.mn,*